



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/80/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Архангай аймаг Өндөр-Улаан сум 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Монголиан бизнес рейтинг аудит ХХК Утас: 70005329 Цахим хаяг:mbr.audit.llc@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЕБ	Ерөнхий боловсрол



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨНДӨР-УЛААН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Л.ЦЭВЭЛМАА
ТАНАА

Аодл. 02.24 № 70

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,299,069.18	82,144,628.18
35	БАРАА МАТЕРИАЛ	90,299,069.18	82,144,628.18
351	Түүхий эд материал	-	1,913,750.00
35130	Эм боох материал	-	1,913,750.00
354	Хангамжийн материал	90,299,069.18	80,230,878.18
35410	Бичиг хэргийн материал	244,079.32	303,829.32
35420	Аж ахуйн материал	78,047,848.36	67,916,077.36
35430	Сэлбэг хэрэгсэл	9,220.00	125,850.00
35440	Түлш, шатах тослох материал	445,000.00	445,000.00
35450	Барилгын засварын материал	3,263,700.00	2,998,700.00
35460	Хүнсний материал	9,500.00	161,700.00
35470	Бусад хангамжийн материал	8,279,721.50	8,279,721.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,524,070,409.19	2,600,306,603.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,524,070,409.19	2,600,306,603.97
392	Биет хөрөнгө	2,448,784,409.11	2,525,520,603.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,576,340,101.42	2,576,340,101.42
39202	Хуримтлагдсан элэгдэл	(258,289,963.69)	(343,293,586.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	210,974,566.42	243,709,603.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(129,631,208.73)	(80,000,195.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	156,386,177.05	139,375,344.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(133,774,797.60)	(41,273,703.96)
39209	Зам, гүүрийн байгууламж	19,860,954.00	17,060,954.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(6,277,143.16)	(3,196,190.88)
39217	Ном	13,195,723.40	16,798,278.84
393	Биет бус хөрөнгө	75,286,000.08	74,786,000.16
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(499,999.92)	(999,999.84)
39303	Бусад биет бус хөрөнгө	74,286,000.00	74,286,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,614,369,478.37	2,682,451,232.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,614,369,478.37	2,682,451,232.15
51	Засгийн газрын хувь оролцоо	2,614,369,478.37	2,682,451,232.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	633,067,002.12	633,067,002.12
512	Хуримтлагдсан үр дүн	901,993,030.00	970,074,783.78
51210	Өмнөх үеийн үр дүн	901,993,030.00	901,993,030.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	68,081,753.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,079,309,446.25	1,079,309,446.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,614,369,478.37	2,682,451,232.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,338,654,685.81	1,412,565,326.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,433,685.81	199,379,148.74
120	Нийтлэг татварын бус орлого	93,433,685.81	199,379,148.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	93,433,685.81	199,379,148.74
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	93,433,685.81	199,379,148.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,245,221,000.00	1,213,186,178.18
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,164,140,400.00	1,148,681,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,164,140,400.00	1,148,681,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,834,600.00	12,929,978.18
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,834,600.00	4,929,978.18
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,246,000.00	51,574,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,415,200.00	51,574,600.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	18,830,800.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,359,175,218.45	1,344,483,573.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,359,175,218.45	1,344,483,573.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,308,437,225.98	1,305,336,503.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	926,352,266.00	910,060,800.00
210101	Үндсэн цалин	631,632,852.00	655,469,200.00
210102	Нэмэгдэл	207,141,214.00	176,867,600.00
210104	Урамшуулал	87,578,200.00	77,724,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,297,335.13	118,429,900.00
210201	Тэтгэврийн даатгал	78,825,313.02	84,293,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,343,322.66	8,534,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,423,819.75	6,827,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,790,779.98	1,706,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,914,099.72	17,068,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,412,200.00	43,520,800.00
210301	Гэрэл, цахилгаан	11,517,014.00	10,624,200.00
210302	Түлш, халаалт	41,436,786.00	32,683,600.00
210303	Цэвэр, бохир ус	458,400.00	213,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,782,196.48	12,823,128.18
210401	Бичиг хэрэг	1,086,850.00	996,128.18
210402	Тээвэр, шатахуун	4,717,900.00	2,885,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,373,090.00	769,300.00
210404	Ном, хэвлэл	3,857,100.00	3,926,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	223,600.00	971,800.00

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	903,200.00	3,273,600.00
210408	Бараа материал акталсны зардал	7,620,456.48	
2105	Нормативт зардал	39,613,322.00	55,180,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,456,450.00	14,276,350.00
210502	Хоол, хүнс	36,772,562.00	38,947,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,384,310.00	1,956,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,792,800.00	2,274,400.00
210604	Урсгал засвар	2,792,800.00	2,274,400.00
2107	Томилолт, зочны зардал	551,900.00	-
210702	Дотоод албан томилолт	551,900.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,471,600.00	17,238,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,871,600.00	16,438,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	144,163,606.37	145,808,624.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,671,332.00	8,666,917.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	139,492,274.37	137,141,707.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,737,992.47	39,147,070.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,412,880.00	37,762,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	132,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,640,980.00	35,999,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	771,900.00	1,631,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,325,112.47	1,384,270.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,325,112.47	1,384,270.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(20,520,532.64)	68,081,753.78
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,357,600.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,357,600.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,357,600.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(21,878,132.64)	68,081,753.78

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,245,221,000.00</u>	<u>1,213,186,178.18</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,245,221,000.00	1,213,186,178.18
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,164,140,400.00	1,148,681,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,164,140,400.00	1,148,681,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,834,600.00	12,929,978.18
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,834,600.00	4,929,978.18
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,246,000.00	51,574,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,415,200.00	51,574,600.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	18,830,800.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,219,090,200.00</u>	<u>1,195,944,178.18</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,219,090,200.00</u>	<u>1,195,944,178.18</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,168,573,087.53</u>	<u>1,156,744,178.18</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	926,352,265.77	906,909,500.00
210101	Үндсэн цалин	631,632,851.77	652,317,900.00
210102	Нэмэгдэл	207,141,214.00	176,867,600.00
210104	Урамшуулал	87,578,200.00	77,724,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,591,921.76	121,581,200.00
210201	Тэтгэврийн даатгал	80,474,854.12	87,444,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,748,353.45	8,534,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,085,562.30	6,827,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,945,435.06	1,706,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,337,716.83	17,068,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,412,200.00	43,565,200.00
210301	Гэрэл, цахилгаан	11,517,014.00	10,624,200.00
210302	Түлш, халаалт	41,436,786.00	32,596,000.00
210303	Цэвэр, бохир ус	458,400.00	345,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,381,300.00	11,388,978.18
210401	Бичиг хэрэг	1,162,300.00	1,081,878.18
210402	Тээвэр, шатахуун	4,500,000.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,505,500.00	769,300.00
210404	Ном, хэвлэл	4,602,500.00	3,990,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	441,500.00	945,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,169,500.00	1,602,100.00
2105	Нормативт зардал	40,323,200.00	56,132,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,485,800.00	15,224,300.00
210502	Хоол, хүнс	35,578,800.00	39,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,258,600.00	1,808,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	2,009,400.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	2,009,400.00
2107	Томилолт, зочны зардал	551,900.00	-
210702	Дотоод албан томилолт	551,900.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,845,300.00	9,501,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,245,300.00	8,701,400.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,115,000.00	5,655,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,115,000.00	5,655,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,517,112.47	39,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,192,000.00	37,815,730.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,924,000.00	36,115,730.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	1,700,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,325,112.47	1,384,270.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,325,112.47	1,384,270.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>26,130,800.00</u>	<u>17,242,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,300,000.00	17,242,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,300,000.00	17,242,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,300,000.00	17,242,000.00
223001	Бусад хөрөнгө	7,300,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	17,242,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,300,000.00)</u>	<u>(17,242,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,830,800.00	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	633,067,002.12	1,079,309,446.25	942,701,962.64	2,655,078,411.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	633,067,002.12	1,079,309,446.25	942,701,962.64	2,655,078,411.01
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(40,708,932.64)	(40,708,932.64)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	633,067,002.12	1,079,309,446.25	901,993,030.00	2,614,369,478.37
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	633,067,002.12	1,079,309,446.25	901,993,030.00	2,614,369,478.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	633,067,002.12	1,079,309,446.25	901,993,030.00	2,614,369,478.37
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	68,081,753.78	68,081,753.78
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	633,067,002.12	1,079,309,446.25	970,074,783.78	2,682,451,232.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,200,256,200.00	1,198,871,930.00	(1,384,270.00)	99.88%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,200,256,200.00	1,198,871,930.00	(1,384,270.00)	99.88%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,161,206,200.00	1,161,206,200.00	-	100.00%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	906,909,500.00	906,909,500.00	-	100.00%
210101	Үндсэн цалин	652,317,900.00	652,317,900.00	-	100.00%
210102	Нэмэгдэл	176,867,600.00	176,867,600.00	-	100.00%
210104	Урамшуулал	77,724,000.00	77,724,000.00	-	100.00%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,581,200.00	121,581,200.00	-	100.00%
210201	Тэтгэврийн даатгал	88,201,000.00	87,444,700.00	(756,300.00)	99.14%
210202	Тэтгэмжийн даатгал	8,345,100.00	8,534,200.00	189,100.00	102.27%
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,676,000.00	6,827,300.00	151,300.00	102.27%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,669,000.00	1,706,800.00	37,800.00	102.26%
210205	Эрүүл мэндийн даатгал	16,690,100.00	17,068,200.00	378,100.00	102.27%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,565,200.00	43,565,200.00	-	100.00%
210301	Гэрэл, цахилгаан	9,686,100.00	10,624,200.00	938,100.00	109.69%
210302	Түлш, халаалт	33,879,100.00	32,596,000.00	(1,283,100.00)	96.21%
210303	Цэвэр, бохир ус	-	345,000.00	345,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	6,847,000.00	6,847,000.00	-	100.00%
210401	Бичиг хэрэг	586,300.00	586,300.00	-	100.00%
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	3,000,000.00	-	100.00%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	769,300.00	769,300.00	-	100.00%
210404	Ном, хэвлэл	439,000.00	439,000.00	-	100.00%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,300.00	450,300.00	-	100.00%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,602,100.00	1,602,100.00	-	100.00%
2105	Нормативт зардал	56,132,800.00	56,132,800.00	-	100.00%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,196,600.00	15,224,300.00	27,700.00	100.18%
210502	Хоол, хүнс	39,100,000.00	39,100,000.00	-	100.00%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,836,200.00	1,808,500.00	(27,700.00)	98.49%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,009,400.00	8,009,400.00	-	100.00%
210604	Урсгал засвар	8,009,400.00	8,009,400.00	-	100.00%

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,701,400.00	10,701,400.00	-	100.00%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,901,400.00	9,901,400.00	-	100.00%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	-	100.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,459,700.00	7,459,700.00	-	100.00%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,459,700.00	7,459,700.00	-	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,050,000.00	37,665,730.00	(1,384,270.00)	96.46%
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,050,000.00	37,665,730.00	(1,384,270.00)	96.46%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,500,000.00	36,115,730.00	(1,384,270.00)	96.31%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,550,000.00	1,550,000.00	-	100.00%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,200,256,200.00	1,198,871,930.00	(1,384,270.00)	99.88%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,148,681,600.00	1,147,297,330.00	(1,384,270.00)	99.88%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,148,681,600.00	1,147,297,330.00	(1,384,270.00)	99.88%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	51,574,600.00	51,574,600.00	-	100.00%
132001	Орон нутгийн төсвөөс	51,574,600.00	51,574,600.00	-	100.00%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	82.00	82.00	-	100.00%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	47.00	47.00	-	100.00%
620003	Үйлчлэх ажилтан	34.00	34.00	-	100.00%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	786.00	786.00	-	100.00%
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	786.00	786.00	-	100.00%
630001	Төрийн өмчит ЕБС	786.00	786.00	-	100.00%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	82.00	82.00	-	100.00%
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	48.00	48.00	-	100.00%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	34.00	34.00	-	100.00%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,929,978.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,929,978.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,779,978.18
2104	Хангамж, бараа материалын зардал	4,779,978.18
210401	Бичиг хэрэг	495,578.18
210404	Ном, хэвлэл	3,789,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	495,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,929,978.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,929,978.18
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,929,978.18
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Солонготуяа, аудитор А.Жамъян нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер Н.Алтанзул, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд бүрд чанартай боловсрол олгож, авьяасыг нээн хөгжүүлж, эрүүл ахуйн зөв дадал, хүмүүжлийн эерэг хандлагыг төлөвшүүлэхэд оршино”.

Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сургууль хүний хөгжлийн төв байх;
- Ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлж хууль дүрмийг хэрэгжүүлэх;
- Ажлын хариуцлага ёс зүй хууль дүрмийг хэрэгжүүлэх;
- Үйл ажиллагааны менежментийн хамгийн оновчтой хувилбарыг цогцлоон хөгжүүлэх;
- Сургалтыг дэмжих үйл ажиллагаа;
- Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос

төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсүгэй"

- Монгол Улсын Засгийн газрын 2021 онд баталсан Үдийн хоолны норматив тогтоох тухай 237 дугаар тогтоолын 1-д "Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 1500 төгрөг", 2-д "...6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1800 төгрөг"-өөр тогтоосугай гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод хяналтын журам, заавар боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, хяналт хийж, тайланг захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна. Харин дотоод хяналтыг зөвхөн сургалтын үйл ажиллагаа, анги танхимын эрүүл ахуй, хүүхдийн эрүүл мэнд, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлагын хүрээнд хийж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,359.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 27.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 21.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68.1 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	90.3	82.1	(8.2)
Биет хөрөнгө	2,448.8	2,525.5	76.7
Биет бус хөрөнгө	75.3	74.8	(0.5)
Нийт хөрөнгө	2,614.4	2,682.5	68.1
Засгийн газрын оруулсан капитал	633.1	633.1	-
Хуримтлагдсан үр дүн	902.0	970.1	68.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,079.3	1,079.3	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,614.4	2,682.5	68.1

3.5.1. Бараа материалын дансны үлдэгдэл 82.1 сая төгрөг болж 8.2 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 9.8 сая төгрөгийн аж ахуйн материал худалдан авч 22.8 сая төгрөгийн материал зарцуулж 10.1 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

3.5.2. Биет хөрөнгө дансны үлдэгдэл 76.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд БСУГ-аас 107.6 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 75.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, 1.1 сая төгрөгийн хашааг шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Архангай аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 654 дугаар шийдвэрээр элэгдлээрээ өртгөө нөхсөн 69 нэр төрлийн 215 ширхэг 45.4 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж тайлагнасан байна.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 0.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлын 0.5 сая төгрөгийн өсөлтөөс шалтгаалжээ.

3.5.3. Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 970.1 сая төгрөг болж 68.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 196.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, цалин шимтгэлийн зардал 13.2 сая төгрөгөөр, бусад бараа үйлчилгээний зардал 2.4 сая төгрөгөөр, нийт үйл ажиллагааны зардал 14.7 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 14.7 сая төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал байхгүй.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мян.төг/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,241,386.4	1,200,256.2	(41,130.2)
Үндсэн үйл ажиллагааны орлого	93,433.7	-	(93,433.7)
Нэмэлт санхүүжилтийн орлого	3,834.6	12,930.0	(9,095.4)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	196,135.9	196,135.9
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	3,243.2	3,243.2
Үйл ажиллагааны орлого	1,338,654.7	1,412,565.3	73,910.6
Цалин, шимтгэлийн зардал	1,041,649.6	1,028,490.7	(13,158.9)

Бусад бараа үйлчилгээний зардал	116,152.4	113,798.4	(2,354.0)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,471.6	17,238.7	10,767.1
Бараа үйлчилгээний бусад зардал	144,163.6	145,808.6	1,645.0
Урсгал шилжүүлэг	50,738.0	39,147.1	(11,590.9)
Хөрөнгө шилжүүлсэн	-	-	-
Үйл ажиллагааны зардал	1,359,175.2	1,344,483.6	(14,691.6)
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,357.6	-	(1,357.6)
Үйл ажиллагааны бус үр дүн	(1,357.6)	-	1,357.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(21,878.1)	68,081.7	89,959.8

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 41.1 сая төгрөг буюу 3.3 хувиар буурсан нь цар тахалтай холбоотойгоор хичээл сургалтын үйл ажиллагааг цахим, танхим хосолсон хэлбэрт шилжүүлсэнтэй холбоотойгоор санхүүжилт буурсан байна. Тайлант онд БШУЯ-аас 196.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан нь үйл ажиллагааны нийт үр дүн өсөхөд нөлөөлсөн байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 1,078.2 сая, орон нутгийн төсвөөс 56.0 сая, нийт 1,134.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан байна.

Тайлант хугацаанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолыг үндэслэн сумын төсөвт 2 удаа өөрчлөлт оруулж, төсвийг 66.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,200.3 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд: Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 9.6 сая төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 77.7 сая төгрөгөөр өсгөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,200.3 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 1,148.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 51.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,147.3 сая, орон нутгийн төсвөөс 51.6 сая, нийт 1,198.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,198.9 сая төгрөгийг зарцуулж 100 % гүйцэтгэлтэй ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,198.9 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь төрөөс иргэдэд олгох тэтгэмж, шагнал урамшууллыг 1.4 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БШУС-ын 2021 оны А/280 дугаар тушаалаар “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн 8.0 сая, түрээсийн номын үнэ 3.8 сая, дээд шатны байгууллагуудаас 1.1 сая төгрөг, нийт 12.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 12.9 сая төгрөг буюу 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 99.8 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,200.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,198.9 сая төгрөгийг зарцуулж, 99.8 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:
 - Түлш халаалтын зардал 1.3 сая төгрөгийг хэмнэж ажилласныг гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардал хүрэлцэхгүй байсан тул шилжүүлэн зарцуулсан байна.
 - Тэтгэврийн даатгалын зардлыг 0.8 сая төгрөгөөр хэмнэж ажилласныг тэтгэмжийн даатгал, ҮОМШӨ-ний даатгал, ажилгүйдлийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал руу хуваарилан зарцуулсан байна.
 - Албан конторын тавилга, шагнал, албан томилот, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлаагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
 - Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллыг 1.4 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.
2. Цар тахлын хандив тусламжтай холбоотой: Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс 0.4 сая төгрөгийн хандив тусламжийг хүлээн авч зориулалтын дагуу 0.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 91.3 сая төгрөгийн мэдээллээс 88.7 сая төгрөгийн мэдээллийг хугацаанд

нь бүрэн 5.2 сая төгрөгийн 5 саяас дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг оруулаагүй мөн 6 мэдээллийг хугацаа хоцроосон, 5 мэдээллийг огт оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.4, 6.5.6 дахь заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг бүрэн оруулаагүй зөрчил давтан гарч байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг тулган шалгахад цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардалд 0.2 сая төгрөгийн шагналын материал, 0.1 сая төгрөгийн тендерийн урамшуулал, 0.6 сая төгрөгийн онцлох ажилтан, шилдэг ажилтны шагнал зэрэг зардлуудыг бууруулж ажиллаагүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3, 1.5 дахь заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, зөрчил арилгах 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 75 хувьтай байгаа ба бараа материалын дэлгэрэнгүй тайланд 21 нэр төрлийн 9.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчлийг тайланд онд давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.4 сая төгрөгийн алдааг залруулж, 1.2 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар анхан шатны баримт болох цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдээгүй баримтуудыг нөхөж и-баримтыг шивүүлж залруулав. Үүнд:

Тус байгууллагын худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 1.4 сая төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримт болох цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдээгүй байсныг аудитын явцад харилцагч 5 аж ахуйн нэгж, байгууллагаас нөхөж и-баримтуудыг бүртгүүлж анхан шатны иж бүрдлийг хангаж залруулав.

4.2 Зөвлөмж

Аудитын код АРА-2022/80/НА-СТА-ТШЗ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.2.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1.5 "Энэхүү журмын 1.4 д зааснаас бусад тохиолдолд Дотоод хяналтыг зохион байгуулах журмыг тухайн байгууллага аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

4.2.2 Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Түлш шатах, тослох материалын дансанд 0.4 сая төгрөгийн аж ахуйн материал бүртгэсэн, аж ахуйн материалын дансанд 14 ширхэг 0.8 сая төгрөгийн сандал ширээ бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн тодорхойлолт 13 дугаар зүйл Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө: а.Бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үйлдвэрлэлт буюу нийлүүлэлтэд, бусдад түрээслэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа; б.Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн дансны зааврын 1 дүгээр хавсралтыг хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Өндөр-Улаан сумын ЕБС	3	2.6	1	1.4					2	1.2
Дүн		3	2.6	1	1.4					2	1.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Өндөр-Улаан сумын ЕБС	2	-					2	-	-	-
Дүн		2	-					2	-	-	-
Нийт дүн		5	2.8	1	1.4			2	-	2	1.2



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 161/2022-ЭБ

Цэцэрлэг

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Өндөр-Улаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитаар тайлант онд шагналын материал худалдан авах 239.0 мянга, тендерийн урамшуулал 150.0 мянга, оны онцлох ажилтан, шилдэг ажилтны шагналд 600.0 мянга, нийт 989.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2 "шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх", 1.3 "... цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх ..." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан зөрчлийг арилгаж биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Архангай аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өндөр-Улаан сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Цэвэлмаа, нягтлан бодогч Ё.Эрдэнэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.НЭРГҮЙБААТАР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ





АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 168/А0350213

Цэцэрлэг

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Өндөр-Улаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитаар байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих 149 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроосон, 5 мэдээллийг огт байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал", 2021 оны А/108 тушаалын хавсралтаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 3.1.1 "Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй бол зөрчил арилгах албан шаардлага өгөх" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж мэдээллийг нөхөн байршуулан биелэлтийг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өндөр-Улаан сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Цэвэлмаа, нягтлан бодогч Е.Эрдэнэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.НЭРГҮЙБААТАР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ

